



# ГҮНГЭРВАА 2016



2016 | #01

ТЭРГҮҮН НҮҮР

www.gungervaa.mn



## ГҮНГЭРВАА - ISO ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

15 ид 2015 оны 7 дугаар сараас эхлэн Монголын Бүтээмжийн Төв (МРО), Азийн Бүтээмжийн Байгууллага (АРО) -тай хамтран чанарын удирдлагын тогтолцоо ISO 9001, материалын урсгал зардлын тооцоолол ISO 14051 зэрэг олон улсын стандартыг нэвтрүүлэх төсөл эхлүүлэн амжилттай хэрэгжүүлж дэлхийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн удирдлага, үйл ажиллагааны туршлагуудаас суралцаж, хэрэглэгч үйлчлүүлэгчдийнхээ эрэлт хэрэгцээг чанарын өндөр түвшинд хангах чадамжтай болсоор байна.



*ГҮНГЭРВАА КОМПАНИ нь 1998 оноос эхлэн барилга, эрчим хүчний барилга угсралтын салбарт үйл ажиллагаагаа эрхэлж салбартаа туршилагатай тэргүүлэх түвшинд хүрлээ. Цаашид шинэ шинэ салбарт үйл ажиллагаагаа өргөжүүлж эдийн засаг, дэд бүтцийн хөгжилд том үүрэг биелүүлж, даацтай далайцтай төслүүдэд хамтран оролцож үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилт тавиад байна. Энэ бүх хугацаанд бидэнтэй хамтран ажиллаж буй бүх харилцагч байгууллагууддаа амжилттай хамтран ажилласанд талархаж буйгаа албан ёсоор илэрхийлж энэхүү бяцхан хэвлэлийг илгээж буйг тинь хүлээн авна уу.*

*Ирж буй 2016 ондоо ажил хөдөлмөрийн өндөр амжилтыг хамтран бүтээж Монгол улсынхаа хөгжилд томоохон дэвшилийг бий болгоно гэдэгт итгэж байна.*

*хүндэтгэсэн*

*“ГҮНГЭРВАА” ХХК -ийн  
ерөнхий захирал*



*/ Б.БАТСАЙХАН /*



# БИД ЮУ БҮТЭЭДЭГ ВЭ?

ГҮНГЭРВАА компани нь бүх төрлийн барилгын болон дэд бүтцийн байгууламжийн бетон, төмөр бетон эдлэлийн үйлдвэрлэлийг 1998 оноос эхэлж дагнан эрхэлсээр, арвин туршлага хуримтлуулж бетон тулгуурын тэргүүлэх үйлдвэр болжээ. Бид Монгол улс дахь томоохон бүтээн байгуулалтад гар бие оролцон, үндэсний шилдэг аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж эх орны хөгжил дэвшилд тогтвортой хувь нэмрээ оруулсаар байна.

Манай компани нь бетон хийцийн үйлдвэрлэлээс гадна орон нутгийн тээвэр, шинэ технологийн мяндаст полимер арматурын үйлдвэрлэл, мөн хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт үйл ажиллагаа эрхэлж хэрэглэгч, харилцагчиддаа чанартай бүтээгдэхүүн, уян хатан үйлчилгээг санал болгож байна.



*Бид бүтээн байгуулалтын эзэд. Байгалийн гаралтай түүхий эдийг ариг галтай, үр ашигтай хэрэглэхийн тулд байгальд ээлтэй, ногоон технологийг хэрэгжүүлэхийг зорьж байна. Мөн бидний онцлох бүтээгдэхүүн болох бетон тулгуур нь аглаг ногоон ойгоос мод огтлохоос сэргийлэхийн зэрэгцээ эрчим хүчийг хотоос хот, суурингаас суурингийн хооронд холбох үндсэн материал болж өгдгөөрөө бахархууштай юм. 2006 оноос эхлэн үйлдвэрлэсэн бетон тулгуур нь Монголын 21 аймагт эрчим хүчний барилга угсралтад ашиглагдаад байгаа билээ.*

*гүйцэтгэх захирал  
Б.АРИУНБОЛД*

# ТҮҮХЭН ТОВЧОО

**2002**  
Япон улсын засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр “Дулааны цахилгаан станц 4” ТӨХК -н зуухны шинэчлэлийн ажлыг гүйцэтгэв.

**2006**  
Монгол Улсын MNS 4232:2000 стандартын дагуу Монгол улсад анх удаа цахилгаан дамжуулах урьдчилан хүчитгэсэн арматуртай 8-12 метрийн урттай төмөр бетон тулгуур шон үйлдвэрлэж эхэлснээр үйлдвэрийн цар хүрээг 2 дахин нэмэгдүүлж, 30 гаруй нэр төрлийн бетон хийц үйлдвэрлэх үйлдвэрлэлийн чадамжтай болов.

**2008**  
Үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор Арматур бэлтгэлийн цехийг барьж байгуулав.

**2011**  
“MCS интернэйшнл” ХХК -ийн гүйцэтгэсэн Мандалговь - Тавантолгой чиглэлийн 220 кВ -ын ЦДАШ -ын төмөр бетон сууриудыг үйлдвэрлэж нийлүүлэв.

**2014**  
“Хасу Мегаватт” ХХК -ийн гүйцэтгэсэн Амгалан дулааны станцын бүтээн байгуулалтад бетон эдлэхүүн нийлүүлэв.

**1998**

“ГҮНГЭРВАА” ХХК үүсгэн байгуулагдаж, 11000 м.кв талбайд суурийн блок үйлдвэрлэхээс анхны ажлын гараагаа эхлэв.

**2004**

Сонгинохайрхан дүүргийн 1-р хороонд Гүнгэрваа худалдааны төвийн барилгыг барьж ашиглалтанд оруулав.

**2007**

Гүнгэрваа худалдааны төвд шинэчлэл хийж, үйл ажиллагааг өргөтгөн “Ариун Гүнгэрваа” ХХК -г байгуулав.

**2010**

“MCS интернэйшнл” ХХК -ийн туслан гүйцэтгэгчээр ажиллан Өмнөговь аймагт баригдсан Ухаа Худаг Цахилгаан Станцын бүтээн байгуулалтын төмөр бетон хийц эдлэхүүнүүдийг үйлдвэрлэн нийлүүлэв.

**2013**

Бетон хийцийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор бетон цутгалтын цехийн барилгыг шинэчлэн барьж, компанийн оффисын барилгыг барьж ашиглалтад оруулав.

Мөн “Хасу Мегаватт” ХХК -ийн гүйцэтгэсэн Улаанбаатар хотын дулааны 5Б төв магистраль шугамын бетон эдлэхүүнүүдийг нийлүүлэв.

**2015**

Монголын бүтээмжийн төв, Азийн Бүтээмжийн байгууллага, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны ЖДҮ -г дэмжих төсөлтэй хамтран ISO 9001, ISO 14051 зэрэг олон улсын стандартыг нэвтрүүлэх төслийг 2015 оны 7-р сард эхлүүлэв.

# БИДНИЙ БИЗНЕСИЙН БОДЛОГО

## ЭРХЭМ ЗОРИЛГО:

ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ БАЯЛГИЙГ БҮТЭЭЖ,  
ХАМТЫН ХҮЧЭЭР ХӨГЖЛИЙГ ТЭРГҮҮЛНЭ.

## ХЭТИЙН ЗОРИЛТ:

2021 ОН ГЭХЭД,  
БИД ХЭРЭГЛЭГЧ, АЖИЛТАН БҮРИЙН ШИЛДЭГ СОНГОЛТ,  
НОГООН ТЕХНОЛОГИОР МАНЛАЙЛАГЧ, ОРОЛЦОГЧ  
ТАЛУУДАД ӨНДӨР ӨГӨӨЖТЭЙ КОМПАНИ БОЛНО.

## ЭРХЭМЛЭДЭГ ҮНЭТ ЗҮЙЛС:

### 1. ЧИН ЭРМЭЛЗЭЛТЭЙ, БҮТЭЭЛЧ ХАМТ ОЛОН

- Бид атгасан гар мэт эв нэгдэлтэй, эерэг харилцаатай, өөриймсөг хамт олон байна.
- Бид үнэ цэнэ, баялгийг бүтээхийн тулд цөхрөлтгүй эрэл хайгуул хийж шаргуу хөдөлмөрлөнө.
- Бид дундаж биш, бид шалгарсан бүтээгдэхүүнийг шилдэг үйлчилгээгээр хүргэхийг эрмэлзэнэ.
- Бид бага шагт ихийг бүтээнэ. Хариуцлага ба санаачлага бол хамгийн том хэмнэлт.

### 2. ШИНИЙГ ЭРЭЛХИЙЛЭГЧ, СУРАЛЦАГЧ БАЙГУУЛАГА

- Бид өөрчлөлтийг өөрсдөөсөө эхлүүлж, гаргасан алдаанаасаа хурдан суралцаж урагш тэмүүлнэ.
- Оюун ухаан бол бүх баялгийн эх сурвалж тул үргэлж өөрсдийгөө шинэ мэдлэгээр цэнэглэж, өөртөө болон байгууллагадаа үнэ цэнэ нэмнэ.
- Суралцах эрмэлзэл бол хөгжлийн наад захын шаардлага тул суралцах зорилго, хүсэл тэмүүлийг дэмжин ажиллана.
- Хөгжил бол эмх цэгц гэдгийг санаж оновчтой шийдвэрийг хурдан гаргаж алтан цагийг хожиж ажиллана.

### 3. ИТГЭЛ ДААСАН ТҮНШЛЭЛ

- Хариуцлага бол хариу өгөх чадвар тул түргэн шуурхай үйлчилгээг нэн тэргүүнд тавина.
- Нийлүүлэгч, харилцагчдын сайн хамтрагч нь байж түншлэлийг хөгжүүлэх нь бидний эргэх холбоо, өсөн дэвжих үндэс суурь юм.
- Өрсөлдөөнд хурдыг эрхэмлэж, алтан боломжийг алдалгүй ашиглана.
- Хүнд суртал, хөшүүн хандлага гаргахгүй.

### 4. НЭЭЛТТЭЙ ШУДАРГА ХАРИЛЦАА

- Нээлттэй шударга харилцааг бий болгож үл хүндлэл, хөндий хүйтэн байдлыг гаргахгүй.
- Итгэл төрүүлэхүйц нээлттэй харилцааг бий болгож, тэгш оролцоог хангаж хамтдаа зорилгодоо хүрнэ.
- Ур чадвар, ажлын үр дүнг харгалзсан, шударга үнэлгээг мөрдөн ажиллана.
- Хууль дүрмийг чандлан мөрдөж, ирээдүйн эрсдэлээс зайлсхийнэ.
- Хэлсэн үг, хийсэн үйлдэлдээ эзэн байна.

### 5. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

- Бид оролцогч, сонирхогч талуудын ашиг сонирхлыг хүндэтгэн, хүрээлэн буй орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологи, арга аргачлал, бизнесийн ёс зүй, санаачлагыг үйл ажиллагаандаа өргөнөөр нэвтрүүлэхийг зорино.
- Ажиллагсдынхаа нийгмийн асуудалд анхаарал тавьж, тэднийг эрүүл, аюулгүй орчинд хөдөлмөрлөх нөхцөлөр хангахын зэрэгцээ хувь хүний болон мэргэжлийн хувьд өсч, хөгжих боломжоор тэгш хангана.
- Буян бол баялаг гэдгийг санаж, нийгэмд сайн сайхан хүмүүнлэг үйл ажлыг идэвхитэй дэмжиж, зохион байгуулан, аливаад өөриймсөг хандаж, баялгийг зөв зорилгод зарцуулна.

## ЧАНАРЫН БОДЛОГО:

БИД ЧАНАРЫГ ЭРХЭМЛЭГЧ, ХЭРЭГЛЭГЧЭЭ ДЭЭДЭЛСЭН,  
ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙЖ ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ӨДӨР  
ТУТАМ САЙЖРУУЛАН, ШАЛГАРСАН БҮТЭЭГДЭХҮҮН  
ҮЙЛЧИЛГЭЭГ ТАНД ХҮРГЭНЭ.

# БИЗНЕСИЙН БУСАД САЛБАРУУД

## АРИУН ГҮНГЭРВАА ХХК - ГҮНГЭРВАА ХУДАЛДААНЫ ТӨВ



Гүнгэрваа худалдааны төв нь 2004 оноос хүнс барааны захын үйл ажиллагааг Сонгинохайрхан дүүргийн 1-р хороонд эхлүүлж хотын баруун бүсийн хэрэглэгчдэд үйлчилгээг ойртуулан төвлөрүүлсэн билээ. Өнөөдөр манай худалдааны төв 25 түрээслэгчтэй халуун ус, банк, өдөр өнжүүлэх төв, хүнс барааны бөөний худалдаа гэх мэт олон төрлийн үйлчилгээг үзүүлж байна.

2015 онд “Ариун Гүнгэрваа ХХК” өөрийн эзэмшлийн 1 га гаруй талбайг Сонгинохайрхан дүүргийн Худалдаа, үйлчилгээний хэлтсийн шийдвэрээр Хангай захын оронд баруун бүсийн түлээ, нүүрс, барилгын материалын зах болгохоор шийдвэрлэсэн бөгөөд үйл ажиллагаа нь 2016 оны хавар эхлэхээр төлөвлөөд байна.

## ОРОН НУТГИЙН ТЭЭВЭР



Барилгын материалыг ажлын талбар дээр шаардлагатай цагт тоо ёсоор бэлэн байлгах нь барилга угсралтын ажил гүйцэтгэгч байгууллагын хувьд чухал хариуцлагатай ажил юм. Тиймээс тэр чухал боловч зарим тохиолдолд хүндрэлтэй байдаг тээвэрлэлтийн ажлыг хөнгөвчлөх зорилгоор бид 2010 оноос орон нутгийн тээврийн үйлчилгээг хэрэглэгчиддээ үзүүлсээр ирсэн багагүй туршлагатай билээ.

Үйлдвэрлэгч = Тээвэрлэгч байх нь таны худалдан авсан бүтээгдэхүүний бүрэн бүтэн байдлыг бид таны “Ажлын талбар” хүртэл хариуцдагаараа гуравдагч талд тээврийг хариуцуулснаас үргэлж давуу талтай байдаг юм. Орон нутгийн тээврийн үйлчилгээг манай туршлагатай жолооч нар, бүрэн даатгагдсан, найдвартай тээврийн хэрэгслийн хамтаар та бүхэнд санал болгож байна.

## БАЯНГҮН ФЕРМ ( Сэлэнгэ аймаг, Ерөө сум )



Гүнгэрваа ХХК хөдөө аж ахуйн чиглэлээр туслах аж ахуйг 2014 оноос эхлэн Сэлэнгэ аймгийн Ерөө сумын байгалийн үзэсгэлэнт газар болох Ерөө голын бэлчирт байгуулж байсан бөгөөд өдгөө 500 гаруй хонь, үхэр, гахай, олон төрлийн шувуу, туулай, мөн үржүүлгийн загас гэх мэтийг өсгөн үржүүлж байна. Мөн нэг дор 30-40 хүн хүлээн авах хүчин чадалтай амралтын шинэ байртай агротуризмын цогцолборын ажил хэрэгжүүлж эхэллээ.

Бидний ногоон технологийг хөгжүүлж, Монголын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгын хүрээнд бид аж ахуй дээрээ хүнсний ашигт болон эм эмчилгээний ногоон ургамлыг тариалж байна. Топинамбур буюу газрын лийр хэмээх гайхамшигт ургамлын эхний ургацаа амжилттай хурааснаар бид биохимийн туршилтыг эхлүүлэх боломжтой болсон билээ. Цаашид бид энэхүү ургамлаас гаргаж авах анхны инулины үйлдвэрийн төслийн судалгааны ажлыг мөн хийж эхлээд байна.

## КОМПОЗИТ АРМАТУРЫН ҮЙЛДВЭРЛЭЛ



Бид бетон эдлэхүүний чанарыг сайжруулах зорилгоор судалж, хэрэгжүүлж эхэлсэн композит арматурын үйлдвэрлэлийн төсөл маань өнгөрсөн 2015 онд амжилттай хэрэгжиж мяндас-полимер материал (FRP) болон мяндас-полимер арматурын Монгол улсын стандартыг боловсруулж батлуулсан билээ. Энэхүү шинэ төрлийн композит арматур нь бидний өргөн хэрэглэдэг ердийн метал арматураас ойролцоогоор 3 дахин илүү суналтын бат бэхтэй, 6-8 дахин хөнгөн, зэвэрдэггүй, цахилгаан гүйдэл дамжуулагдгүй, харьцангуй хямд үнэтэй зэрэг олон олон давуу талуудтай.

Композит арматурыг иргэний ба үйлдвэрлэлийн барилгад хэрэглэхээс гадна зам, гүүр, усны барилга байгууламж, газар доорх байгууламж, далд уурхайн ханын бэхлэгээ, цахилгаан гүйдэл дамжуулагдгүй хийцүүдэд хэрэглэхэд хамгийн тохиромжтой материал юм.

ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦСЭН  
ЧАНАРТАЙ БҮТЭЭГДЭХҮҮН  
*БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ*  
*ҮЙЛДВЭРЛЭЛ*

НАЙДВАРТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА  
УЯН ХАТАН, ШУУРХАЙ ҮЙЛЧИЛГЭЭ

---

**БИДЭНТЭЙ ХОЛБОГДОХ**

---

ЗАХИАЛГА ӨГӨХ УТАС: +976 99101551  
80301551

Утас | Факс: +976 70170777  
Э-шуудан: [gungervaa@gmail.com](mailto:gungervaa@gmail.com)  
Веб хуудас: [www.gungervaa.mn](http://www.gungervaa.mn)

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот  
Баянгол дүүрэг, 20-р хороо  
Энхтайваны өргөн чөлөө  
554 тоот

Ш/х: Улаанбаатар 37/164